

Та хүсэлтийг үнэн зөв гаргалтай бөглөнө үү!

Please, complete the form correctly and clearly!

Огноо: 20..... оны ..... сарын ..... өдөр

Date: YYY Y MM DD

**Дансны валютаа сонгоно уу:**

Please, choose desired currency:

Төгрөг MNT  Ам.доллар USD

**Картын төрлөө сонгоно уу:**

Please, choose card type:

Энгийн карт Classic card  Алтан карт Gold card  Цалингийн карт Salary card  Орифлэйм карт Oriflame card

**Lady Лоялти картаа сонгоно уу:**

Please, choose lady loyalty card type:

Classic card  Pink card  Premium card

**Карт эзэмшихээр хүсэлт гаргагчийн мэдээлэл:** Cardholder's information:  Эрэгтэй Mr  Эмэгтэй Ms, Mrs

Эггийн нэр /эхийн/: Сurname: \_\_\_\_\_ Нэр: Given name: \_\_\_\_\_ Ургийн овог: Family name: \_\_\_\_\_

Төрсөн огноо: Date of birth: \_\_\_\_\_ Иргэний харьяалал: Nationality: \_\_\_\_\_ Боловсрол: Education: \_\_\_\_\_

Регистерийн № Register №: \_\_\_\_\_ Иргэний үнэмлэхийн № Identification №: \_\_\_\_\_

Гэрийн хаяг: Хот / Аймаг: City/Aimag: \_\_\_\_\_ Дүүрэг / Сум: District / Sum: \_\_\_\_\_ Хороо / Баг: Khoroо / Bag: \_\_\_\_\_

Хороолол / Гудамж / Хотхон: Micro district / Street: \_\_\_\_\_ Байр: Building: \_\_\_\_\_ Тoot: Flat №: \_\_\_\_\_

Холбоо барих: Утас: Home phone: \_\_\_\_\_ Гар утас: Cell phone: \_\_\_\_\_ Электрон шуудан: Email address: \_\_\_\_\_

Ажил эрхлэлт: Employment:  Ажилтай Employed  Хувиараа Self-employed  Оюутан Student  Тэтгэвэрт Pensioner

Байгууллагын нэр: Company name: \_\_\_\_\_ Газар / Хэлтэс: Business sector: \_\_\_\_\_ Албан тушаал: Position: \_\_\_\_\_

Байгууллагын хаяг: Company address: \_\_\_\_\_ Утас: Tel No: \_\_\_\_\_ Факс: Fax: \_\_\_\_\_

**Нууц үг:** Confidentiality: Та картаа хаяж үргэгдүүлсэн тохиолдолд энэ тухай банкинд утсаар нэн даруй мэдэгдэж картанхаа гүйлгээ хийх эрхийг хаалгах үүрэгтэй. Таны мэдэгдлийг хүлээн авахдаа банкны ажилтан нууц үгийг тань асуух болно. Түүнчлэн карт болон картан данснаах талаар банкнаас утсаар лавлагаа авах шаардлагатай бол та нууц үгээ зөв хариулж картан жинхэнэ эзэмшигч гэдгээ нотлох юм. Иймд танаас өөр хүн амархан хариулж чадахааргүй нууц үг сонгож нууцлалыг нь чандлан хадгална уу.

In case card is lost it is clients' responsibility to inform the bank immediately in order to stop all transactions. Upon receiving your request bank staff can ask your password. You can obtain all necessary information via phone by correctly answering password to confirm the authenticity of card holder. Therefore, please select password not easily interpreted by others bank officer will disclose your password.

Асуулт: Question: \_\_\_\_\_ ? Хариулт: Answer: \_\_\_\_\_

**Карт дээр миний нэрийг доорх байдлаар хэвлэж өгнө үү: (латин үсгээр, 18 тэмдэгтээс илүүгүй)**

Please fill the Applicant's name in the boxes below as it should appear on the business card: (maximum 18 characters)

\_\_\_\_\_

**Картаар зарцуулах лимит:** Card spending limit:  Би банкнаас тогтоосон дараах лимитийг зөвшөөрч байна: I would like to amend the limit that is set.

Картын гүйлгээний эрсдэлийг бууруулах үүднээс картаар 1 өдөрт хийх гүйлгээний тоо, дүнд банк тодорхой лимитүүд тавьдаг.

Banks limit number of daily card transactions in order to prevent and reduce risks of card transactions.

Дээд хэмжээ /1 өдөрт/ maximum limit /1 day/	Төгрөг MNT		Ам.доллар USD	
	Энгийн карт Classic card	Премум карт Premium card	Энгийн карт Classic card	Премум карт Premium card
АТМ-аас бэлэн мөнгө авах ATM cash limit	3,000,000	4,000,000	Төгрөгийн лимитээр Would be same like MNT limit	
Худалдан авалт хийх болон бэлэн мөнгө авах Purchase and cash advance	3,000,000	6,000,000	Төгрөгийн лимитээр Would be same like MNT limit	

Интернетээр худалдан авалт хийх пин код бүртгүүлэх (Картын пин кодтой адилхан болно) Register internet PIN code /would be same as card PIN code/

**Интернетээр дансны хуулга авах нууц код:**

(латин жижиг үсгээр болон тоогоор) Нууц кодынхоо нууцлалыг чандлан хадгална уу.

Register password for card account online statement: (Lowercase Roman and Digits. Please keep your password security.)

\_\_\_\_\_

Та хүссэн үедээ <http://www.bankcard.mn> хаягаар орж дансны хуулга авах боломжтой. Check your card account statement <https://www.bankcard.mn> anytime

**Мессеж картны үйлчилгээ / SMS card service**

Мессеж бүр 50₮ per message MNT 50

Амжилттай хийгдсэн худалдан авалтын гүйлгээний мэдээлэл авах: To get information of successful transactions on purchases

25,000₮ -с дээш дүнтэй гүйлгээ/ on purchases with equal to 25,000 MNT or over  100,000₮ -с дээш дүнтэй гүйлгээ/ on purchases with equal to 100,000 MNT or over  200,000₮ -с дээш дүнтэй гүйлгээ/ on purchases with equal to 200,000 MNT or over

Амжилттай хийгдсэн худалдан авалт болон АТМ-ын гүйлгээний мэдээллийг авах: To get information of successful transactions on purchases, and get information on ATM transactions

25,000₮ -с дээш дүнтэй гүйлгээ/ on purchases with equal to 25,000 MNT or over  100,000₮ -с дээш дүнтэй гүйлгээ/ on purchases with equal to 100,000 MNT or over  200,000₮ -с дээш дүнтэй гүйлгээ/ on purchases with equal to 200,000 MNT or over

Картын хүчинтэй хугацаа дуусах талаар мэдээлэл авах. Card expiry information  Картын дансанд орлого орсон талаарх мэдээлэл. To get information on deposits into card account

Амжилттай болсон бүх төрлийн гүйлгээний мэдээллийг электрон шуудангаар (и-мэйл) авах. Жилийн хураамж 1500₮ Information on every successful transaction can be viewed via e-mail. Annual fee MNT 1500

**Мессеж банкны үйлчилгээ SMS banking service**

Та картан дансаа төлөөлөх тоог 1-99 хүртэлх тооноос (1-9 хүртэлх тооны хувь нэг оронтой байна) сонгоно уу. Please, choose any number from 1 to 99 for each of your accounts and that particular number will represent your account.

Төгрөгийн дансыг төлөөлөх тоо: Number to represent MNT account:

\_\_\_\_\_ MNT

Ам.долларын дансыг төлөөлөх тоо: Number to represent USD account:

\_\_\_\_\_ USD

Карт хүлээн авах: Card Receiving:  Би картаа ажлын 2 өдрийн дараа хүлээж авахыг хүсч байна. I'd like to receive the card in 2 days.  Би картаа яаралтай (ажлын 6 цагийн дотор) хэвлүүлж авахыг хүсч байна. Холбогдох шимтгэлийг миний данснаас суутгаж авахыг зөвшөөрч байна. I'd like to receive the card in 6 hours (working). I agree that, relevant fees will be charged from my account.

**Тантай холбоо барих боломжгүй үед танд мэдээлэл дамжуулах боломжтой хүний мэдээлэл:** Name of the person to be contacted in case of emergency

Эггийн нэр /эхийн/: Surname: \_\_\_\_\_ Нэр: Name: \_\_\_\_\_ Таны юу болох: Relation (eg.Father): \_\_\_\_\_

Гэрийн / Ажлын утас: Home / telephone: \_\_\_\_\_ Гар утас: Cell phone: \_\_\_\_\_ Электрон шуудан: E-mail: \_\_\_\_\_

Би дээрх маягтыг үнэн зөв бөглөсөн болохыг баталж байна. Би Худалдаа, хөгжлийн банкны "Монгол улсад хэрэглэгдэх төлбөрийн дебит карт эзэмших гэрээ"-ний нөхцөл болон картан үйлчилгээний хуу, шимтгэлийг хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав.

I confirm that the information given above is correct and complete; have read/ understand the General Terms and conditions of Trade and Development bank of Mongolia.

Карт эзэмшихээр хүсэлт гаргагчийн баталгаат гарын үсэг: Authorized signature: \_\_\_\_\_

**Банкны хэрэгцээнд: BANK USE ONLY:**

Харилцагчийн дугаар: \_\_\_\_\_ Мэдээллийг оруулсан ажилтан: \_\_\_\_\_ Тайлбар \_\_\_\_\_ Карт нээсэн салбар \_\_\_\_\_

## Худалдаа, Хөгжлийн Банкны Монгол Улсад хэрэглэгдэх Төлбөрийн Дебит карт эзэмших гэрээ

201... оны ..... -р сарын ..... -ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Худалдаа, хөгжлийн банкны Монгол Улсад хэрэглэгдэх Төлбөрийн Дебит карт эзэмших гэрээ (цаашид **"Гэрээ"** гэх)-г нэг талаас Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж 7, Бага тойруу 12 хаягт орших Худалдаа, хөгжлийн банк (цаашид **"Банк"** гэх), нөгөө талаас Монгол улсад хэрэглэгдэх "Төлбөрийн дебит карт эзэмших хүсэлт"-ийн маягт (цаашид **"Хүсэлтийн маягт"** гэх) дээр гарын үсэг зурсан иргэн (цаашид **"Карт эзэмшигч буюу урамшуулалт төлбөрийн карт эзэмшигч"**, хамтад нь **"Талууд"** гэх), нар дараах нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Гэрээний зүйл

Энэхүү Гэрээний дагуу банк нь харилцагчийн хүсэлтээр Монгол улсад хэрэглэгдэх Төлбөрийн дебит карт (цаашид **"Карт"** гэх)-ыг харилцагчид олгож, үйлчилгээ үзүүлэх, карт эзэмшигч нь картаа ашиглан төлбөр тооцоо хийх, карт ашигласны төлбөрийг банкинд төлөх зэрэг талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх хариуцааг зохицуулах.

Карт нь банкны өмч бөгөөд картыг төлбөрт хүлээж авах эрхтэй үйлчилгээний байгууллагуудад худалдаа, үйлчилгээний үнэ хөлсийг төлөх, АТМ (бэлэн мөнгөний автомат машин) болон банкны зүгээс үзүүлж буй бусад гүйлгээ хийх, нэмэлт үйлчилгээг авахад зориулагдсан төлбөрийн хэрэгсэл болно. Карт нь карт эзэмшигчийн банкинд дахь дансдтай холбогдсон, уг дансдыг төлөөлөх төлбөрийн хэрэгсэл мөн.

### Хоёр. Карт олгох

Банк, харилцагчийн бүрдүүлсэн дор дурдсан баримт бичиг, нөхцлийг харгалзан үзэж карт олгоно. Үүнд:

18 нас хүрсэн байх, **7-18** хүртэлх насны этгээд нь өөрийн хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, харгалзан дэмжигч)-өөс нь бичгээр зөвшөөрөл олгогдсон тохиолдолд;

Карт эзэмшигчийг хүссэн тухай банкны баталсан хүсэлтийн маягтыг үнэн зөв бөглөсөн байдал;

Иргэний үнэмлэх эх хувиар, **7-16** хүртэлх насны этгээдийн хувьд төрсний гэрчилгээ, гадаад паспортын хуулбар;

Картын үйлчилгээний холбогдох хураамж, төлбөрийг бүрэн төлсөн байх. Үүнд:

Картын дансны доод үлдэгдэл;

Картын жилийн хураамж.

Банкнаас шаардсан бусад шаардлагыг хангасан байх.

Банк дээрх баримт бичгүүд бүрдсэн тохиолдолд картыг карт эзэмшигчдэд олгоно.

### Гурав. Банкны эрх, үүрэг

Банк нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

Карт эзэмшигч картыг хэрхэн хэрэглэх талаар заавар, зөвлөмж өгөж;

Банкны терминал (АТМ, PC teller, BankPos)-аас болон банкны харъяа газар, нэгж дээр биеэр ирж өгсөн харилцагчийн гүйлгээ хийх хүсэлт, захиалга, төлбөрийн даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэх;

Карт эзэмшигчийн картын дансдын үлдэгдэлд Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл (цаашид **"Хүү, шимтгэлийн нөхцөл"** гэх)-д заасны дагуу хүү бодож олгож;

Тухайн карт эзэмшигчийн картын онцлогоо хамааран банктай гэрээ бүхий картын үйлчилгээний байгууллага (цаашид **"КҮБ"** гэх)-уудаас картаараа худалдан авсан бараа, үйлчилгээний нийт дүнд ногдох урамшуулал эсвэл оноог хүү, шимтгэлийн нөхцөлд заасны дагуу тооцож, карт эзэмшигчийн картын санхүүгийн үндсэн дансанд эсвэл онооны дансанд шилжүүлж байх;

Карт эзэмшигч, КҮБ-аас өөрийн картаараа төлбөрийг нь төлсөн бараа, үйлчилгээг буцаасан бол холбогдох дүнг харилцагчийн картын санхүүгийн үндсэн данс руу, урамшуулалт хөтөлбөрт хамрагдсан картын хувьд КҮБ-аар үйлчлүүлснээс олгосон оноотой тэнцэх мөнгөн дүнг КҮБ-ын данс руу буцаан оруулах;

Картын төлбөр, тооцоотой холбогдон карт эзэмшигч болон банктай гэрээ бүхий КҮБ-ын хооронд үүссэн маргаантай асуудлыг карт эзэмшигч, КҮБ хоёрын аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор хамтран шийдвэрлэх;

Бусад банкны сүлжээнд гарсан төлбөр тооцоотой холбоотой асуудлыг Банкны сэжигтэй маргаантай, луйврын шинжтэй гүйлгээ илрүүлэх, шалгах болон шийдвэрлэх журмын дагуу шийдвэрлэнэ.

Гэрээт банкны сүлжээнд гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд карт эзэмшигчийн хүсэлтийн дагуу гэрээт банктай холбогдон карт эзэмшигчийг төлөөлөн харцах;

Карт эзэмшигчийн хүсэлтээр дансны хуулга болон гүйлгээний талаарх мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөж;

Карт эзэмшигчийн картын данс, карт эзэмшигчийн талаарх бусад мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд чандлан хадгалах.

Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:

Картын үйлчилгээний шимтгэлийг хүү, шимтгэлийн нөхцөлд заасны дагуу карт эзэмшигчийн картын данснаас суутган авах;

Банк нь хүү, шимтгэлийн нөхцлийг санхүү, мөнгөний зах зээл, үйлчилгээний хүрээ, ачаалал, харилцагчийн эрэлт хэрэгцээг харгалзан өөрийн санаачилгаар өөрчлөж;

Карт эзэмшигчээс шинэ болон нэмэлт карт авах, хүчинтэй хугацаа нь дууссан, гэмтсэн, алдаж үрэгдүүлсэн картын оронд нөхөж карт авах хүсэлтийг хүлээн авч, карт олгох, татгалзах эсэхийг шийдвэрлэх;

Карт эзэмшигчийн картаараа хийсэн төлбөр, тооцоог тухай бүр холбогдох данснаас нь суутган авч байх;

КҮБ-аас картаар хийгдсэн бараа, үйлчилгээний төлбөр дутуу дүнгээр хийгдсэн тухай хүсэлт гаргасан бол холбогдох баримтыг үндэслэн, карт эзэмшигчид танилцуулсны үндсэн дээр зөрүү дүнг харилцагчийн картын данснаас суутган авах;

Өндөр дүнтэй, нэг дүнгээр олон удаагийн үйлдлээр гүйлгээ хийсэн, луйврын байж болошгүй гүйлгээ хийгдэж буй картыг карт эзэмшигч болон холбогдох боломжтой хүнээс баталгаажуулж чадаагүй тохиолдолд банк нь дансыг тухай;

Урамшуулалт төлбөрийн карт эзэмшигчдэд хуримтлуулсан оноогоороо зөвхөн урамшуулалт КҮБ дээр зарцуулалт хийх боломжтой ба уг оноог бэлэн мөнгөн дүнгээр өгөх/авах боломжоор хангахгүй;

Банк нь урамшуулалт төлбөрийн карт эзэмшигчдэд урамшууллын оноог зөвхөн бэлэн бусаар холбогдох дансанд олгож;

Карт эзэмшигч энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон төлбөрийн карт хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрсөн тохиолдолд банк дараах арга хэмжээг авах эрхтэй. Үүнд:

Тухайн карт, нэмэлт карт (ууд)-ын гүйлгээ хийх эрхийг зогсоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг карт эзэмшигчээс шаардах;

Карт эзэмшигчийн буруугаас Банк, КҮБ буюу бусад хохирол учирсан нь тогтоогдсон бол карт эзэмшигчийн картын болон бусад данснаас суутган авах, дансны үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;

Карт эзэмшигчийн картаар хийх гүйлгээ болон гүйлгээний дүнд тодорхой хязгаарлалтуудыг тогтоох;

Карт эзэмшигч нь карт хэвлүүлэх захиалга өгсөнөөс хойш 1 жилийн хугацаанд картаа авч ашиглаагүй бол картыг хүчингүй болгох;

Карт эзэмшигч нь сүүлийн 2 жилийн турш картын дансаар гүйлгээ хийгээгүй, дансны үлдэгдэл нь 0-ээс их боловч дансны доод үлдэгдэлд хүрэлцэхгүй бол карт болон дансыг хаах;

АТМ-д хураагдсан картыг КЭ-д мэдэгдсэнээс хойш 1 сарын дотор буцаан аваагүй бол картыг хүчингүй болгох;

Карт эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлээгүй бол гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, карт эзэмшигчээс картыг буцаан авах.

Тухайн карт, нэмэлт картын гүйлгээ хийх эрхийг зогсоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг карт эзэмшигчээс шаардах.

### Дөрөв. Карт эзэмшигчийн эрх, үүрэг

Карт эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

Банкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлтэй танилцан зөвшөөрсний үндсэн дээр энэ гэрээнд заасны дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн холбогдох картын данс (цаашид **"Данс"** гэх) нээлгэн, түүнийг төлөөлөх карт авч, түүгээр төлбөр тооцоо хийж;

Дансандаа банкнаас тогтоосон заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах;

Дансны үлдэгдлийг улайлгасан тохиолдолд Банкны хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасны дагуу торгууль болон улайлгасан дүнг яаралтай төлж барагдуулах;

Өөрийн дансан дахь хөрөнгийг хамтран эзэмших эрхтэй нэмэлт карт эзэмшигчийн төлбөр, тооцоог болон түүнтэй холбогдон үүсэх эрсдэлийг бүрэн хариуцах;

Карт эзэмшигчийг хүссэн тухай банкны баталсан өргөдлийн карт дээр бөглөсөн мэдээлэл өөрчлөгдөх бүр энэ тухай банкинд мэдэгдэж байх, мэдэгдээгүйн улмаас үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;

Өөрийн картыг гээсэн, хулгайд алдсан тохиолдолд банкны 24 цагийн үйлчилгээний 326289 дугаарын утсаар мэдэгдэж картаа хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;

Картын данснаас ямар нэгэн маргаантай буюу хүлээн зөвшөөрөөгүй гүйлгээ хагасдан тохиолдолд гүйлгээ хагасданаас хойш хуанлийн 30 хоногийн дотор банкинд мэдэгдэж шалгуулах;

Картын гүйлгээтэй холбоотой үүсгэсэн маргааныг шалгах явцад карт эзэмшигч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болон төлбөрийн карт хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан зардлыг хариуцах;

Карт эзэмшигч нь АТМ-аас бэлэн мөнгө авах, КҮБ-аар төлбөр, тооцоо хийх зэрэг картын гүйлгээ бүрт банкнаас өгсөн пин кодыг ашиглаж үүрэгтэй бөгөөд пин кодоо мартсан, буруу уруулсан шалтгаанаар гүйлгээ хийж чадаагүйгээс үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;

Карт эзэмшигч нь интернэт худалдан авалтад зориулсан интернэт пин кодыг банкны АТМ-аас авах үүрэгтэй бөгөөд интернэт пин код оруулаагүй хийгдсэн гүйлгээний аливаа эрсдэлийг бүрэн хариуцах;

Карт эзэмшигч нь өөрийн карт болон картын дугаар, хүчинтэй хугацаа, картын нууцлалын дугаар, пин код, интернэт пин код зэрэг нууцлалын мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх дамжуулсанаас үүссэн хохирлыг бүрэн хариуцах;

Карт эзэмшигч нь өөрийн карт болон картын соронзон туузны мэдээлэл, картын нууцлалыг бусдад алдахаас сэргийлэх

"Банкнаас өгсөн **Дотоодын төлбөрийн карт хэрэглэх заавар**"-ыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэг зөрсөнөөс үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;

Гэрээт банкны сүлжээнд картаа ашиглаж байгаа тохиолдолд тухайн банкны нэмэлт хүү, шимтгэл болон ханшийн зөрүүг бүрэн хариуцах;

Карттай холбоотой дараах нэмэлт үйлчилгээг зөвхөн данс нээсэн салбарт ирж авах:

1.15.1 Гарын угсийн баталгаа солих;

1.15.2 Карт, картын данс хаалгах;

1.16. Гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлэх.

2. Карт эзэмшигч нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

2.1 Банкнаас өөрийн дансны үлдэгдэл болон гүйлгээний талаар хуулга, мэдээ, тайлбар авах;

2.2 Гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлэхийг банкнаас шаардах;

2.3 Банкнид бичгээр өргөдөл гаргаж, дансаа хамтран эзэмших эрхтэй нэмэлт карт (ууд)-ыг бусдад олгуулах;

2.4 Банкнид бичгээр хүсэлт гарган, нотариатараар баталгаажуулсан өөрийн өв залгамжлагч болон данс ашиглах эрх бүхий хүнийг тодорхойлох;

2.5 Хүчинтэй хугацаа нь дууссан, гэмтсэн буюу алдаж, үрэгдүүлсэн картанхаа оронд банкинд бичгээр хүсэлт гаргаж шинээр карт авах;

Өөрийн хүсэлтээр картаа хугацаанаас нь өмнө хүчингүй болгуулах;

Картын төлбөр, тооцоотой холбогдон үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар банкинд хандах;

Карттай холбоотой дараах нэмэлт үйлчилгээг банкны дурын салбарт ирж авах:

2.8.1. Картын хүчинтэй хугацаа дууссан, гээсэн, алдсан болон гэмтсэн шалтгаанаар карт дахин хэвлүүлэх;

2.8.2. Картын пин код шинэчлэн авах;

2.8.3. Интернэтээр дансны хуулга авах, гар утсаараа дансныхаа үлдэгдлийг шалгах үйлчилгээнд бүртгүүлэх;

2.8.4. Картын гүйлгээний мэдээллийг гар утсаар болон и-мэйлээр хүлээн авах үйлчилгээнд бүртгүүлэх;

Урамшуулалт төлбөрийн карт эзэмшигч нь хуримтлуулсан оноогоороо зөвхөн банктай гэрээ байгуулсан КҮБ-д зарцуулалт хийх.

### Тав. Картаар хийх гүйлгээнд тавих хязгаарлалт

Картаар хийх гүйлгээний аюулгүй байдлыг хангах үүднээс банк карт эзэмшигчийн картанд дараах хязгаарлалтуудыг тогтооно. Үүнд:

Үйлчилгээний байгууллагууд болон банкны харъяа салбар тооцооны төвөөс өдөрт үйлчлүүлэх гүйлгээний дээд хэмжээ;

АТМ-аас авах бэлэн мөнгөний дээд хэмжээ;

АТМ-аар өдөрт үйлчлүүлэх гүйлгээний тоо;

Үйлчилгээний байгууллагууд болон банкны харъяа салбар тооцооны төвөөс өдөрт үйлчлүүлэх гүйлгээний тоо;

PIN кодоо зөв оруулах оролдлогын тоо.

Карт эзэмшигч нь энэхүү гэрээний 5.1.1-5.1.4 дэх хэсэгт заасан хязгаарлалтыг өөрчлүүлэх тухай хүсэлтээ уг данс нээлгэсэн салбар дээр ирж өгөх бөгөөд энэхүү хүсэлт гүйлгээний түүх болон бусад мэдээллийг үндэслэн банк шийдвэрээ гаргах ба шийдвэрийн дагуу банкны эрх бүхий ажилтан өөрчилнө.

Карт эзэмшигч нь Гэрээний 5.1.1-5.1.4 дэх хэсэгт заасан хязгаарлалтыг яаралтай өөрчлүүлэх тухай хүсэлтээ өөрийн утсаар болон электрон хаягаар гаргасан тохиолдолд гүйлгээний түүх болон бусад мэдээллийг үндэслэн түр хугацаагаар өсгөх эсэх талаар банк шийдвэр гаргах ба шийдвэрийн дагуу банкны эрх бүхий ажилтан өөрчилнө.

### Зургаа. Гэрээний хугацаа, гэрээ дуусгавар болно

Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болсноос хойш аль нэг талаас гэрээг цуцлах хүсэлт гаргах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байх ба дараах тохиолдолд гэрээг цуцалж гэрээний хугацааг дуусгавар болгоно. Үүнд:

Нэг талаас карт эзэмшигчийн өөрийн хүсэлтээр, нөгөө талаас банкны нэг талын санаачилгаар карт эзэмшигчийн карт эзэмших эрхийг зогсоож, дансыг хааснаар энэхүү гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцно;

Хэрвээ карт эзэмшигч нь картын данстай холбогдох аливаа өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй бол тухайн төлбөрийг хүүгийн хамт бүрэн барагдуулж дуусалт картын дансанд хаалт тавьж, барагдуулж дууссан өдрөөс гэрээг цуцалж, гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцно.

Энэхүү гэрээ нь гэрээний нөхцөл бүрэн биелэгдэж гэрээ цаашид сунгагдахгүй болсноор, гэрээг аль нэг талын санаачилгаар хугацаанаас өмнө цуцалснаар дуусгавар болно.

Банк нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулсан тухай бүр гэрээг шинэчлэгдсэнд тооцно.

### Долоо. Маргаан шийдвэрлэх

Картын төлбөр, тооцоотой холбоотой карт эзэмшигч болон банкны гэрээт КҮБ-ын хооронд үүссэн маргаантай асуудлыг карт эзэмшигч, КҮБ-ын аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор хамтран зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.

Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.

Хэрэв энэ гэрээний 7.1, 7.2-д заасан журмаар маргааныг шийдэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### Найм. Хариуцлага

Карт эзэмшигч өөрийн картын болоод нэмэлт картаар хийсэн төлбөр тооцоо, үйлчилгээний хураамж, шимтгэлийг банк болон түүний үйлчилгээний байгууллага, бусад харилцагч байгууллага, банкуудын өмнө бүрэн хүлээж хариуцна.

Карт эзэмшигч өөрийн картын найдвартай байнгын ажиллагааны дагуу картын ар талд баталгаат гарын үсгийг зурах, пин код, хүчинтэй хугацааны дууссан хугацааг анхаарч үйлчлүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд банкинд тухай бүр нь мэдэгдэж картаа шалгуулах, картын хугацааг сунгуулах, дахин хэвлүүлэх, пин кодыг шинээр авах үүрэгтэй ба шалгаагүй, банкинд мэдэгдээгүйгээс болж өөрт учирсан элдэв хохирол, асуудлыг харилцагч өөрөө бүрэн хариуцна.

Карт эзэмшигч өөрийн гэрийн хаяг, гар утас, гэрийн утас, и-мэйл хаяг зэрэг карт эзэмших хүсэлтэд бөглөж өгсөн мэдээллүүд өөрчлөгдсөн даруйд Банкнид мэдэгдэж байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүрэг биелүүлээгүйгээс болж үүссэн хохирлыг банк хариуцна.

### Ес. Бусад зүйл

Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санална хэдийд ч гаргаж болох бөгөөд нэмэлт гэрээг бичгээр үйлдсэнээр гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Энэхүү гэрээ нь карт эзэмшигч банкны баталсан "Карт эзэмших хүсэлт"-д гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. **"Карт эзэмших хүсэлт"** нь гэрээний салшгүй хэсэг байна.

Энэ гэрээг банк болон карт эзэмшигч хадгална.